Монгол анагаах ухааны илж нухлах заслаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчилсэн үр дүн

Уудам[1,2], Шуан Мэй[2], Чао Лу[2], Жин ай хуа[2], У.Номин-Эрдэнэ[1], Н.Оюунцэцэг[1]*

[1]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт Эмчилгээний Тэнхим
[2]БНХАУ, ӨМӨЗО-ны Өвөр Монголын Олон Улсын Эмнэлэг
Цахим шуудан: btd23e006@gt.mnums.edu.mn, Утас: 89028789

Түлхүүр үг:

Ууц сүүжний үений эмгэг
Нурууны архаг өвдөлт
Монгол анагаах ухаан
Илж нухлах засал

Товч утга:

Үндэслэл: Сүүлийн жилүүдэд нийгэм эдийн засгийн хөгжлийг даган хүмүүсийн ажил, амьдрал, өдөр тутмын хэв маяг өөрчлөгдсөнөөс шалтгалан удаан хугацаагаар сууж ажиллах эсвэл машин жолоодсоноос хөдөлгөөний хомсдол үүсч, үүнээс шалтгаалан ууц нурууны архаг өвдөлт хүн амын дунд жилээс жилд ихсэж байна. Ууц сүүжний үений эмгэг (Derangement of sacroiliac joint)-ээс үүссэн нурууны өвдөлт нийт өвдөлтийн 22%-ийг эзэлдэг бөгөөд өвчтөнд сууж босох, дээш харж хэвтэхэд зовиуртай, сүүж рүү дамжсан өвдөлт мэдрэгддэгээрээ онцлогтой гэж судуулгачид тэмдэглэсэн байна. Эмчилгээнд стероидын бус үрэвслийн эсрэг эм уулгах, стероид тарих эсвэл физик эмчилгээ, хөдөлгөөн заслын эмчилгээг санал болгодог ба Монгол анагаах ухааны илж нухлах заслаар эмчилж үр дүнг тооцсон судалгаа хийгдээгүй байгаа нь энэх судалгаа хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Монгол анагаах ухааны илж нухлах заслаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчилж үр дүнг тооцох. **Арга, аргачлал:** Судалгааг АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өвөр Монголын Олон Улсын Монгол Эмнэлэг, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлгийг түшиглэн, санамсаргүй хяналтат эмнэлзүйн туршилт судалгааны загвараар ууц сүүжний үений эмгэг оноштой, нурууны архаг өвдөлттэй 18-65 насны, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн, 70 үйлчлүүлэгчийг хамруулан тус бүр илж нухлах бариа заслаар 7 удаагийн эмчилгээ хийв. Эмчилгээний бүлгийн 35 хүнд МАУ-ны илж нухлах бариа заслын арга, хяналтын бүлгийн 35 хүнд TENS-ээр эмчилж үр дүнг нурууны архаг өвдөлтийн JOA асуумж, VAS асуумж судалгааны хуудсыг ашиглан тооцов. **Үр дүн:** Эмчилгээний бүлгийн дундаж нас 43.89±10.49 жил, хяналтын бүлгийн дундаж нас 42.14±8.92 жил байсан ба хоёр бүлгийн хооронд нас, хүйсний хувьд статистик ялгаагүй байв (p>0.05). Эмчилгээний бүлгийн болон хяналтын бүлгийн хүмүүсийн ууц сүүжний үений архаг өвдөлтийг JOA асуумж, өвдөлтийн VAS асуумжаар эмчилгээний өмнө, хойно үнэлэхэд статитистикийн ач холбогдол бүхий ялгаатай байв (p<0.05). Эмчилгээний өмнө 2 бүлгийн JOA, VAS асуумжаар статистик ялгаа байгаагүй ба (p>0.05) эмчилгээний дараа бүлэг хоорондох ялгаа статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байсан (p<0.05) буюу МАУ-ны илж нухлах заслын аргаар эмчилсэн бүлэгт өвдөлт илүү намдсан байлаа. Монгол анагаах ухааны зөөлөн заслын нэг болох илж нухлах заслаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчлэхэд инвазив бус аргаар өвдөлт намдаан, эмнэлзүйн шинж тэмдгийг багасган, амьдралын чанарыг нэмэгдүүлэх үр дүнтэй байна. **Дүгнэлт:** Монгол анагаах ухааны зөөлөн заслын нэг болох илж нухлах заслаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчлэхэд инвазив бус аргаар өвдөлт намдаан, эмнэлзүйн шинж тэмдгийг багасган, амьдралын чанарыг нэмэгдүүлэх үр дүнтэй байна.

Үндэслэл: Ууц сүүжний үений эмгэг (Derangement of sacroiliac joint)-ээс үүссэн нурууны архаг өвдөлт нь хүн төрөлхтний эрүүл мэндэд эрсдэл учруулах гол хүчин зүйлийн нэг болж байна гэж тэмдэглэгдсэн байна. Олон улсын өвдөлтийн судалгааны нийгэмлэгийн 2020 оны судалгаагаар 557 сая хүн нурууны архаг өвдөлттэй гэж мэдээлсэн. Олон улсын хяналт ба урьдчилан сэргийлэх төвийн мэдээлэлд дэлхийн хэмжээнд нурууны архаг

өвдөлт нь бусад өвчнөөс илүү хөдөлмөрийн цадвар алдалтад хүргэж байна гэжээ.[1]

20 дугаар зууны эхэнд нурууны архаг өвдөлтийн хамгийн гол шалтгаан нь ууц сүүжний үений эмгэгээс шалтгаалдаг гэж тэмдэглэсэн бол 1934 онд судлаач Unitt Mixter-Barr бүсэлхий нугалмын жийргэвч, мөгөөрсний эвэрхийн эмгэг нь нурууны архаг өвдөлт үүсгэх шалтгааны нэг гэж үзэж байжээ[2-7]. Гэвч дээрх онол нь орчин үеийн оношилгооны арга болох CT, MRI зэрэг хөгжсөнөөр үгүйсгэгдэж ууц сүүжний үений эмгэг нь нурууны өвдөлтийг үүсгэдэг гол шалтгаан болохыг нотолсон байна. Дэлхийн нийт хүн амын 90% нь нурууны өвчнөөр өвөрмич бус өвдөлтөөр бол түүний дотор ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны өвчин 15-30%-ийг эзэлдэг байна[8]. Уг эмгэг нь хүний бие махбод, сэтгэл санаа, амьдралын чанар, ажлын үр дүнд нөлөөлөх цаашилбал нийгмийн хөдөлмөрийн чадварт нөлөөлж, эдийн засагт хохирол учруулдаг байна. 2021 онд тус өвчнийг эмчлэхэд Австралид жилд 48 тэрбум доллар, Англи улс жилд 28 тэрбум фунд, Америк 100 тэрбум доллар зарцуулжээ. Иймээс тус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх зэрэг нь олон улсад тулгамдсан асуудал болоод байна. Гэтэл өнөөгийн эмчилгээний арга нь тус асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгаа тул илүү үр дүнтэй, аюулгүй, хямд төсөр зардалтай шинэ эмчилгээний аргыг судлах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Монгол анагаах ухааны эртний ном судар, сурвалж бичигт ууц ташааны үений эмгэгээс үүссэн “Нурууны архаг өвдөлт” гэх нэр томьёо, тусгай өвчин гэж ангилж тэмдэглээгүй боловч монгол анагаах ухааны онолоор өвчний шалтгаан, шинж, буусан орон, махбодийг үндэслэн хуян өвчний хүрээнд харьяалагдана. Иймээс Монгол анагаах ухааны оношилгоогоор бадган, шар ус, цус хямралдан цагаан судалд нөлөөлснөөс судлын сүв бөглөрч, хий цусны гүйдэл муудсанаас болж эмчилгээнд “Гишүүний хуян” гэж оношилж, цагаан судлын өвчний хүрээнд багтаажээ[7]. Монгол анагаах ухаанд тус өвчнийг эмчлэх эмчилгээний зарчимд махбодыг тэгшитгэх, хий цусны гүйдлийг сайжруулах, цагаан судлыг нэвтрүүлэх, шар усыг хатаах, муу цусыг арилгах, өвдөхийг зогсоох бөгөөд илж нухлах заслаар ууц ташааны үений зөрж шилжсэн үе гишүүнийг тэгшилдэг. Тус засал нь үр дүн сайтай, өвдөлтийг түргэн намдаах, хийхэд хялбар, эрсдэл ба гаж нөлөөгүй, эмчилгээний үнэ хямд зэрэг давуу талтай байна. Иймээс эмнэлзүйд нотолгоонд суурилсан эмчилгээний аргыг нэвтрүүлэх нь энэх судалганыг хийх үндэслэл болно.

Зорилго: Монгол анагаах ухааны илж нухлах бариа заслаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчилж үр дүнг тооцох.

Арга, аргачлал: Судалгааг эмнэлзүйн санамсаргүй хяналтат туршилт судалгааны загвараар Өвчний олон улсын 10-дугар ангиллын дагуу M24.9 Ууц сүүжний үений эмгэг (Derangement of sacroiliac joint) гэсэн оноштой, нурууны архаг өвдөлттэй 18-65 насны, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн, 70 үйлчлүүлэгчийг хамруулан АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өвөр Монголын Олон Улсын Монгол Эмнэлэг, Монгол Анагаах Ухааны Төв эмнэлгийг түшиглэн гүйцэтгэв. Судалгааг хийхдээ эмчилгээний бүлгийн 35 хүнд илж нухлах бариа засал, хяналтын бүлгийн 35 хүнд TENS-ээр эмчилж үр дүнг нурууны архаг өвдөлтийн JOA асуумж, VAS асуумж судалгааны хуудсыг ашиглан үр дүнг тооцсон.

Судалгааны ажлын ёс зүй: Судалгаа хийх зөвшөөрлийг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж ёс зүйн зөвшөөрөл авсан (№2023/3-07). Судалгаанд хамрагдагсдаас таниулсан зөвшөөрлийн хуудсаар дамжуулан зөвшөөрөл авч, гарын үсгээр баталгаажуулсан болно.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсдын эмчилгээний бүлэгт эрэгтэй n=13 (37%), эмэгтэй n=22 (63%), дундаж нас 43.89±10.49 жил байв. Харин хяналтын булэгт эрэгтэй n=14 (40%), эмэгтэй n=21 (60%), дундаж нас 42.14±8.92 жил, хоёр бүлгийн хооронд нас, хүйсний ялгаа байгаагүй (p>0.05).(Хүснэгт 1)

Хүснэгт 1. Хоёр бүлгийн нас, хүйсийг харьцуулсан дүн


Бүлэг	*n*	Хүйс		Дундаж нас (M±m)	*t*	*p*
		эрэгтэй (%)	эмэгтэй (%)			
Эмчилгээний бүлэг	35	13 (37)	22 (63)	43.89±10.49	0.749	0.457
Хяналтын бүлэг	35	14 (4)	21 (60)	42.14±8.92		

Эмчилгээний бүлгийн 35 хүнд илж нухлах бариа заслын аргаар 7 хоног эмчилгээ, хяналтын бүлэгт TENS эмчилгээг 7 хоног тус бүр хийсэн. 2 бүлэгт эмчилгээний өмнөх болон дараах өвдөлтийг VAS үнэлгээгээр үнэлж үр дүнг тооцсон. Харин эмчилгээ хийлгэхээс өмнө эмчилгээний бүлэг болон хяналтын бүлэг хоорондох VAS үнэлгээний оноог хосолсон түүврийн т-шинжүүр (Paired samples t-test)-ийн аргаар бодоход ялгаа байгаагүй (p>0.05) бол эмчилгээний дараа 2 бүлгийн хоорондох VAS үнэлгээний оноо мэдэгдэхүйц ялгаатай (p<0.05) байлаа.(Хүснэгт 2)

Хүснэгт 2. Эмчилгээний өмнө болон дараах өвдөлтийг үнэлсэн VAS дүн

Бүлэг	*n*	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	*t*	*p*
Эмчилгээний бүлэг	35	7.29±0.57	2.71±0.75	31.813	0.000
Хяналтын бүлэг	35	7.14±1.44	4.06±1.00	23.372	0.000
Бүлэг хоорондын *t*		0.546	6.361		
Бүлэг хоорондын *p*		0.587	0.000		

Дээрх үр дүнгээс үзэхэд ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны өвдөлтийг илж нухлах бариа заслын аргаар эмчлэхэд TENS эмчилгээнээс илүүтэй өвдөлтийг намдааж байна. (Зураг 1)




Зураг 1. Эмчилгээний өмнө болон дараах VAS үнэлгээ, харьцуулалсан дүн

Эмчилгээний болон хяналтын бүлгийн нурууны архаг өвдөлтийг JOA асуумжаар эмчилгээний өмнө, хойно үнэлсэн. Эмчилгээ хийлгэхээс өмнө эмчилгээний бүлэг болон хяналтын бүлгийн хооронд JOA үнэлгээний онооны хувьд ялгаа байгаагүй (p>0.05) бол эмчилгээний дараа хоёр бүлгийн хооронд JOA үнэлгээ статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байлаа (p<0.05). (**Хүснэгт 3**)

Хүснэгт 3. Хоёр бүлгийн эмчилгээний өмнө болон дараах JOA үнэлгээ

Бүлэг	*n*	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	*t*	*p*
Эмчилгээний бүлэг	35	14.37±1.24	24.43±1.31	31.715	0.000
Хяналтын бүлэг	35	12.17±3.37	17.4±2.06	14.526	0.000
Бүлэг хоорондын *t*		3.622	17.019		
Бүлэг хоорондын *p*		0.001	0.000		

Дээрх хүснэгтээс харахад 2 бүлэгт эмчилгээ хийсний дараа JOA үнэлгээгээр илж нухлах засал хийсэн эмчилгээний бүлэгт хяналтын бүлэгтэй харьцуулахад өвдөлтийн байдал статистик ач холбогдол бүхий (p<0.05) ялгаатай байна. Харин эмчилгээ хийлгэхээс өмнө эмчилгээний бүлэг болон хяналтын бүлгийн хооронд JOA үнэлгээний онооны хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдасангүй (p>0.05). (Зураг 2)



Зураг 2. Хоёр бүлгийн эмчилгээний өмнө болон дараах JOA үнэлгээ, харьцуулалсан дүн

Хэлцэмж: Бидний судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн МАУ-ны илж нухлах засал хийлгэсэн эмчилгээний бүлгийн хүмүүст хяналтын бүлгээс илүү үр дүнтэй (p<0.05), өвдөлт мэдэгдэхүйц буурч, амьдралын чанарт нөлөөлж буй нь эмчилэнээр дамжин сайжирсан байна.

Эмнэлзүйн практикт зонхилон тохиолдох нурууны архаг өвдөлтүүдийн шалтгааны нэг ууц сүүжний үений эмгэг (Derangement of sacroiliac joint) нь өвдөлтийн зэрэг, эмнэлзүйд илрэх шинж тэмдгээс болж буруу оношлогдож, тохирсон үр дүнтэй эмчилгээ хийгдэхгүй тохиолдол их байдаг. Тархалтын хувьд ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлт нь нийт нурууны өвдөлтүүдийн 15-30%-ийг эзэлдэг[9] бөгөөд нурууны өвдөлтүүдийн хагасаас илүү нь ууц сүүжний үений эмгэгтэй байдаг. Жирэмсэн эмэгтэйчүүдийн нурууны өвдөлтийн 50% илүү хувь нь ууц сүүжний үений эмгэгээс үүсдэг.[10]

Ууц сүүжний үеийн эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлт нь өдөр тутмын амьдралд олон тохиолддог боловч өвдөлтийн зэрэг, шинж тэмдэг нь харилцан адилгүй байдаг тул хүмүүс анхаардаггүй байна. Ялангуяа «Урт, богино хөл», хүмүүс зогсож байхдаа хазгай зогсох, хөлөө ачих зэрэг нь ууц сүүжний үеийн эмгэгээс үүссэн байдаг.[11]

Өвдөлт нь тус өвчний гол шинж тэмдэг бөгөөд орчин үеийн анагаах ухаанд үрэвслийн эсрэг өвчин намдаах эм, усан эмчилгээ, физик эмчилгээ, үрэвслийн эсрэг тариа, хөдөлгөөн засал эмчилгээг зөвлөдөг. Эмчилгээний үндсэн зарчим нь өвдөлтийг багасгах, хөдөлгөөнийг сэргээх, аарцаг болон ууц сүүжний үеийг тогтворжуулах болно. Харин Монгол анагаах ухаанд нурууны архаг өвдөлтийг “Доод мөчний хуян өвчин» нэрлэн «Цагаан судлын өвчин»-ний ангилалд багтаадаг.[12] Монгол анагаах ухааны онолоор муу цус, шар ус нь ууц сүүж, аарцаг, бүсэлхий нурууны

үе гишүүн, шөрмөс булчинд шунаж, цагаан судлыг бөглөж саатсанаас өвчин үүсгэн, ихэвчлэн урт богино хөлтэй болох, нуруу болон доор мөч рүү өвдөж, аль нэг тал эсвэл 2 хөл рүү бадайрах, мэдээ алдах, алхахад зовиурлах зэрэг шинж тэмдгүүд илэрч байгааг илж нухлах бариа заслын өвөрмөц заслын аргаар эмчилдэг[13]. Энэ эмчилгээний үр дүнд гурван махбодыг тэнцвэржүүлж, хий цусны гүйдлийг сайжруулан, өвдөлтийг намдаах зарчмаар буруу байрлалтай ууц сүүжний үеийг тэгшилж, аарцаг нурууны биомеханик тэнцвэрийг сайжруулан, тулгуур нурууны нугалмын шууд даралтыг бууруулж, хэсэг газрын цусан хангамжийг нэмэгдүүлэн, бодисын солилцоог дэмжиж, булчин, холбоосны наалдац, даралтыг чөлөөлж өгснөөр үрэвслийг намдааж, ууц нурууны үйл ажиллагааг сэргээхийг дэмжиж өгдөг онцлогтой.

МАУ-ны илж нухлах заслын аргаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчилэхд бусад эмчилгээний аргуудтай харьцуулахад аюулгүй, гаж нөлөөгүй, хүндрэлгүй, эмчилгээний үр дүн сайтайгаас гадна гардан үйлдэл хийхэд хялбар, эмчлүүлэгчид таагүй мэдрэмж төрүүлдэггүй, өвдөлтгүй, зардал багатай тул эмнэлзүйд нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Монгол анагаах ухааны зөөлөн заслын нэг болох илж нухлах заслаар ууц сүүжний үений эмгэгээс үүссэн нурууны архаг өвдөлтийг эмчлэхэд инвазив бус аргаар өвдөлт намдаан, эмнэлзүйн шинж тэмдгийг багасган, амьдралын чанарыг нэмэгдүүлэх үр дүнтэй байна.

Ном зүй:

1. *Нурууны өвдөлтийн талаар юу мэдэх хэрэгтэй вэ.Шинэ спорт·тамир, технологи сэтгүүл. 2022;(8):5-7*
2. *Foley BS,Buschbacher RM. Sacroiliac joint pain: anatomy, biomechanics, diagnosis, and treatment.Am J Phys Med Rehabil, 2006;85(12) :997-1006.*
3. *Forst SL, Wheeler MT, Fortin JD, et al., The sacroiliac joint: Anatomy, physiology and clinical significance. Pain Physician,2006,9 (1):61-68.*
4. *Boswell MV, Shah RV, Everett CR, et al., Interventional techniques in the management of chronic spinal pain: Evidence-based practice guidelines. Pain Physician.2005; 8 (1):1-47.*
5. *McKenzie-Brown AM, Shah RV, Sehgal N, et al. A systematic review of sacroiliac joint interventions. Pain Physician.2005; 8(1):115-126.*
6. *Cohen SP. Sacroiliac joint pain: A comprehensive review of anatomy, diagnosis and treatment]. Anesth Analg. 2005;101 (5):1440-1453.*
7. *Чинбат Б, Хай Жин. Жин Ёоны эмчилгээний үйлдвэр.Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, БНХАУ, ӨМӨЗО, Хөх хот.2012;180*
8. *Сүрэнжав Ц. Монгол анагаах ухааны эмчилгээний судлал Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.1999;64.*
9. *Steven P, Cohen,MD□Sacroiliac Joint Pain A Comprehensive Review of Anatomy.Diag— nosis,and Treatment.Anestb Anaig. 2005;101:1440-1453*
10. *Хайфэн Гу, Ан Цинь, Шунву Фан. ууц ташааны үеийн өвдөлтийн мэдрэлийн дамжуулалтын механизмын судалгааны ахиц дэвшил. Гадаадын анагаах ухаан. Ортопедийн хэмжээ.2005;(06):44-46*
11. *Вэнчао Ли, Шиаохуа Си. бэлхүүс-аарцагны бария засалаар Бүсэлхий нурууны мөгөөрсөн жийргэвчийн ивэрхийн эмчилгээний судалгааны ахиц дэвшил . Хятадын уламжлалт анагаах ухааны клиник сэтгүүл . 2022;34 (02):385-389*
12. *Монгол судлалын нэвтэрхий толь редакцийн «Анагаах ухаан» боть редакцийн хороо. Монгол судлалын нэвтэрхий толь·Анагаах ухааны боть. Хөххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн газар.2012;13.*
13. *Мөнхбилэг. Монгол анагаах ухааны илж нухлах заслыг халуун зүү эмчилгээтэй хослуулж Бүсэлхий нурууны мөгөөрсөн жийргэвчийн ивэрхийг эмчилсэн 40 тохиолдлын эмнэлзүйн ажиглалт. Хятадын эрүүл мэндийн хоол тэжээл. 2016;26(16):337.*

The results of treatment of chronic back pain in Derangement of sacroiliac joint by massage therapy of Mongolian medicine

Wudamu[1,2], Shuang Mei[2], Chao Lu[2], Jin Ai Hua[2], Nomin-Erdene U[1], Oyuntsetseg N[1]*

[1]Department of Traditional Therapy, ISSM, MNUMS
[2]Inner Mongolian International Mongolian Hospital, Inner Mongolia, P.R.China
E-mail: btd23e006@gt.mnums.edu.mn, Tel: +976-89028789

Background: In recent years, due to the changes in the workplace, lifestyle, and daily routines following the development of society and economy, stiff back pain due to long periods of sitting or lack of movement due to traffic has been increasing year by year among the population, and the tendency of chronic back pain is increasing. Back pain during sacroiliac joint syndrome accounts for 22% of the total pain, and it hurts in the lower part of the back, near the buttocks, 10 centimeters above the sacrum, because the patient feels painful and radiating pain when sitting up and lying. Non-steroidal anti-inflammatory drugs, steroid injections, and physical therapy have been used clinically, up till now no research has been conducted to evaluate the results of Mongolian traditional medicine massage therapy.

Aim: To evaluate the results of treatment of chronic back pain in sacroiliac joint syndrome using massage therapy of Mongolian medicine.

Materials and Methods: The research was carried out in a randomized controlled clinical trial design with the support of the International School of Mongolian Medicine of MNUMS, Inner Mongolia International Mongolian Hospital of Inner Mongolia, China, and the National Center of Mongolian Traditional Medicine. 70 people aged 18-65 with chronic back pain diagnosed with osteoarthritis of the hip joint, who agreed to participate in the study, were treated 7 times each. 35 people in the treatment group were treated with massage therapy of Mongolian medicine, and 35 people in the control group were treated with TENS. The results were calculated using the JOA back pain evaluation questionnaire and VAS measuring instrument for chronic back pain.

Results: The average age of the treatment group was 43.89±10.49, and the comparison group was 42.14±8.92, and there was no significant difference in age and gender between the two groups ($p>0.05$). The questionnaire of JOA back pain evaluation scores and VAS scores before and after the treatment were statistically different ($p<0.05$) among 35 people treated with massage therapy of Mongo*lian* medicine in the treatment group and the TENS treatment group in the control group. There was no difference in the JOA back pain evaluation questionnaire and VAS scores between the two groups before treatment ($p>0.05$), and after treatment, the difference between the groups was statistically significant ($p<0.05$), or the group treated with massage therapy of Mongolian medicine had an obvious difference.

Conclusion: In the treatment of chronic lumbar back pain caused by sacroiliac joint disorders, this method can effectively reduce pain, reduce clinical symptoms, and improve quality of life.

Keywords: Sacroiliac joint syndrome, Chronic low back pain, Mongolian traditional medicine, Massage therapy